



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ”
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 6/30

Бор-Өндөр сум

Б.Эрдэнэзулын албан тушаалыг өөрчлөн,
түр томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1.4, 78 дугаар зүйлийн 78.1.1, 101 дүгээр зүйлийн 101.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2024 оны 238 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Номын санч Н.Нарантуяа нь жирэмсэн болон амаржсаны амралт авсан тул түүнийг ажилдаа эргэн орох хүртлэх хугацаанд, архив, бичиг хэргийн ажилтан Баатарын Эрдэнэзулыг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн номын санчийн албан тушаалд түр томилсугай.

2.Б.Эрдэнэзулын албан тушаалын үндсэн цалинг ТҮСБ-3 зэрэглэл 1,414,000 (нэг сая дөрвөн зуун арван дөрвөн мянга) төгрөгөөр тогтоож, хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн нэмэгдэл хөлс олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3.Хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн ажиллахыг номын санч (Б.Эрдэнэзул)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.АМАРЖАРГАЛ